

Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3”-ийн хүрээнд хийгдсэн төлөвлөгөөний биелэлт

2024.11.21

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт	Гүйцэтгэл
1	Крилл болон монгол бичгээр албан хэрэг хөтлөх батлагдсан стандартын сургалт зохион байгуулах	Аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан монгол бичгээр албан хэрэг хөтлөх сургалтанд хэлтсийн иргэний болон эд хөрөнгө, хуулийн этгээдийн архивчид, бичиг хэргийн ажилтан нарыг хамруулсан. Үүний дагуу сургалтын талаарх мэдээллийг хэлтсийн улсын бүртгэгч нарт танхимаар, сумдын улсын бүртгэгч нарт онлайнаар хүргэж ажилласан байна.	100 хувь
2	Олон нийтэд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг крилл, монгол бичгээр хослуулан нийтэлж хэвших	Хэлтсийн сайтанд тавигдаж байгаа мэдээллийг монгол бичиг болон крилл бичгээр хослуулан мэдээлэх ажил хийгдэж байна.	100 хувь
3	Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад албан хаагчдыг хамруулах	Сумын улсын бүртгэгчээр шинээр томилогдсон бүртгэгч нараа монгол бичгийн анхан шатны сургалтанд, анхан шатны мэдлэгтэй албан хаагчдыг улам чадавхжиж суралцахыг зөвлөн ажиллаж байна. Хэлтсийн албан хаагчдын дунд ахисан шатны монгол бичгийн танхимын сургалтыг монгол бичгийн зөвлөх багш Цэрэнбалбараар заалгаж мэдлэгээ дээшлүүлж хамрагдсан улсын бүртгэгч нартаа сертификат гардуулсан болно.	100 хувь
4	Байгууллагын нэр хаяг, өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудас, танилцуулга, мэдээллийн самбар зэргийг монгол бичгээр хослуулах	Байгууллагын нэр хаяг, өрөө тасалгааны хаяг, мэдээллийн самбарыг монгол болон крилл бичгээр хослуулан хийлгэсэн бөгөөд цаашдаа тавьж буй мэдээллийг монгол бичгээр хослуулан тавих ажлыг эхлүүлээд байна.	100 хувь
5	Хүний нөөц сургалтын системийн бие даах хичээл цэсэнд “Хүмүүн бичиг” сонин болон цахим хичээлүүдийг байршуулж албан хаагчдыг Монгол бичиг бие дааж сурах орчин нөхцөлийг бүрдүүлэх	Хүний нөөцийн нэгдсэн программд орсон Монгол бичгийн видео хичээл болон 6-10 ангийн хичээлүүд, эрх зүйн хэлтсээс гаргадаг сонингийн монгол бичигтэй мэдээллийг сум болон хэлтсийн албан хаагчдаар судлуулж монгол бичгийн чадвараа сайжруулах талаар онлайн сургалтаар мэдээлэл өгч ажилласан болно.	100 хувь

6	Газар хэлтсүүд монгол бичгийн аян өрнүүлэх	Жил бүрийн 5 сард зохион байгуулагддаг “Номын баяр”-аар аймгийн төв номын сангаас зохион байгуулсан монгол бичгээр цэвэр бичих аянд 2 улсын бүртгэгчийг хамруулснаас гадна хэлтсийн албан хаагчдын дунд уншлага, цэвэр хуулан бичлэг, криллээс монгол бичигт хөрвүүлэн бичих чадвар төрлөөр уралдаан явуулж тус бүр нэг ажилтныг шалгаруулсан байна.	100 хувь
7	Монгол бичгийг албан хаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй суурин / зөөврийн/ компьютерт криллээс монгол бичигт хөрвүүлэх программын сургалт зохион байгуулах	Завхан аймгийн хэмжээнд “Үндэсний бичиг соёлын жил 2024” ажлын хүрээнд Хос бичигтэн нэртэй youtube –д байрласан монгол бичгийн хичээл болон монгол бичгээр компьютерт шивэх зааварчилгааг онлайнаар судлуулснаар албан хаагчид өөрийн компьютероос монгол,криллээр бичих ажлыг хэрэглээнд нэвтрүүлсэн. Үүнээс гадна бүртгэгч нарын компьютерт хүний нэрийн толь, зөв бичих дүрмийн толь суулгуулсан нь криллээс монгол бичигт зөв хөрвүүлэх, алдаагүй бичихэд тус дөхөм болсон.	100 хувь

Тайлан бичсэн: Улсын бүртгэгч

Хянасан: Хэлтсийн дарга



Б.Отгонцэцэг

Ж.Сүхбаатар